



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/400

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн "4", Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "Хан-Алтай ресурс" ХХК-ийн уул уурхайн төслийн хүрээнд хэрэгжиж буй хүдэр боловсруулах үйлдвэрийн урвалжийн агуулах, нуруулдан уусгах байгууламжтай танилцаж, түүнд химийн хорт болон аюултай бодис ашиглахад санал, зөвлөмж, дүгнэлт гаргах, мөн байгууламжийн газрын байршил тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:Г.Хурцгэрэл	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	Х.Баатарзориг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Ж.Мөнхчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, аймгийн Ерөнхий архитектор)

2.

- Д.Эрхэмбаяр (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга, геологи уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч)
- Г.Билэгсайхан (Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)
- А.Оюун-Эрдэнэ (Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч)
- Г.Болд-Эрдэнэ (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Д.Мөнгөнчимэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, цөлжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Б.Содмаа (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны нөөц, ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)
- Б.Жавзмаа (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол, хог хаягдал, химийн бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Г.Энх-Эрдэнэ (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)
- Ц.Батпүрэв ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал)
- Нарийн бичгийн дарга:Б.Цэрэнбал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)
- М.Мөнх-Эрдэнэ ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг зөвшөөрлийн хэлтсийн ерөнхий менежер)

2.Төсөлд химийн хорт болон аюултай бодис ашиглах, тээвэрлэх, хадгалах, устгах үеийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээтэй танилцаж, үр дүнг 2022 оны 07 дугаар сарын 04-ний дотор аймагийн Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (Г.Хурцгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

САМГАЛАНБААТАР

